



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/120


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам”-ыг нэгдүгээр, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтийг хангахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Сүхболд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар нарт тус тус даалгасугай.



О.АЛТАНГЭРЭЛ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны  
11 дугаар сарын 24-ны өдрийн 11/20 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ  
ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ, БАГИЙГ СУРГАЖ БЭЛТГЭХ,  
СОНГОХ, ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ҮЕД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энхийг дэмжих ажиллагаанд (цаашид “ажиллагаа” гэх) оролцуулах цагдаагийн алба хаагч, багийн сургалт, бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах, сонгох, үүрэг гүйцэтгэх үед мөрдөх журамтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

1.3.НҮБ болон бүс нутгийн холбогдох бусад байгууллага, ажиллагаа явагдаж байгаа эсхүл хамтран оролцох улс орны зүгээс энэ журамд зааснаас өөр шаардлага тавьсан тохиолдолд энэ журмын 1.2-т заасныг баримтлан хамтран ажиллах санамж бичиг, техникийн гэрээний хүрээнд сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх харилцааг харилцан зөвшилцөж шийдвэрлэж болно.

1.4.Ажиллагааны сургалт, бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дараах зарчмыг баримтална:

1.4.1.хуулийг дээдэлж, шударга ёс, тэгш байдлыг хангаж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

1.4.2.сургаж бэлтгэх хөтөлбөр, төлөвлөлт нь тухайн ажиллагааны хэрэгцээ, шаардлагад тулгуурласан бодитой байх;

1.4.3.сонгох ажиллагаа нь нээлттэй шударга, ажил мэргэжлийн онцлог, ур чадвар, гүйцэтгэх чиг үүргийг харгалзсан, тэгш хүртээмжтэй, уян хатан байх;

1.4.4.НҮБ-ын энхийг сахиулагчийн болон цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлах;

1.4.5.тухайн ажиллагаанд заасан үүргийн хүрээнд ахлах даргын тушаал, шийдвэрийг биелүүлэх, захирах, захирагдах ёсыг баримтлах;

1.4.6.үүрэг гүйцэтгэх улсын хууль тогтоомжийг мөрдөх, зан заншил, шашин шүтлэгт нь хүндэтгэлтэй хандах;

1.4.7.цагийн байдлын өөрчлөлт, үүрэг гүйцэтгэх үеийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрхийн хязгаарлалтыг дагаж мөрдөх.

1.5.“Цагдаагийн хөгжлийн сан”-тай холбоотой харилцааг холбогдох хууль, журмаар зохицуулна.

**Хоёр.Ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийн сургалт,  
бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах**

2.1.Ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх төлөвлөгөөг хийхдээ энэ талаар гарсан НҮБ-ын шийдвэр, Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, сургалтын төлөвлөгөөг баримтална.

2.2.Ажиллагаанд оролцох сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор батална.

2.3.Цагдаагийн алба хаагч, багийн ажиллагаанд оролцох төрөл, гүйцэтгэх үүргээс хамаарч сургаж бэлтгэх хөтөлбөр, шалгаж үнэлэх, сонгох зааврыг цагдаагийн төв байгууллагын дарга баталж, хэрэгжилтэд цагдаагийн байгууллагын энхийг дэмжих ажиллагааны нэгж хяналт тавина.

2.4.Энэ журмын 2.2-т заасан ажиллагааны сургаж бэлтгэх төлөвлөгөөг ажиллагааны өмнөх сургалт ба ажиллагааны үеийн сургалт гэсэн 2 үе шатаар төлөвлөх бөгөөд ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлийг цагдаагийн төв байгууллага, ажиллагааны үеийн сургалт, бэлтгэлийг цагдаагийн багийн захирагч зохион байгуулна.

2.5.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь ажиллагаанд гүйцэтгэх үүргийн онцлог, тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн мэдлэг, дадлага, ур чадвар олгох, жигдрэлтийг хангах арга хэмжээг бүрэн тусгасан байх бөгөөд тухайн ажиллагааны онцлогоос хамаарч ажиллагааны өмнөх сургалтыг 4-8 долоо хоногийн хугацаагаар төлөвлөнө.

2.6.Ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг дотоодын болон гадаад улсад зохион байгуулагдах сургалт, дадлага, хурал, семинараар сургаж бэлтгэж болно.

2.7.Ажиллагааны өмнөх сургалтаас биеийн эрүүл мэнд, сахилга, ёс зүйн хариуцлага, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн талаар цагдаагийн байгууллагын энэ журмын 2.3-т заасан нэгж нь тухайн алба хаагчийг анх илгээсэн байгууллагад нь даруй мэдэгдэнэ.

2.8.Энэ журмын 2.7-д заасан шалтгаанаар сургалтаас чөлөөлөгдсөн цагдаагийн багийн алба хаагчийг нөөцийн бүрэлдэхүүнээс нөхөн бүрдүүлэх боломжгүй тохиолдолд энэ журмын 3.20-д заасан комисс сонгох ажиллагаа явуулж, цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр сургалтад хамруулна.

2.9.Цагдаагийн төв байгууллагын эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгж цагдаагийн алба хаагч, цагдаагийн багийн дархлаажуулалтын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, баяжилт хийх, шаардлагатай дархлаажуулалтын судалгааг гарган алба хаагч, багийг тогтсон хугацаанд дархлаажуулалтад хамруулна.

2.10.Энэ журмын 2.3-т заасан нэгж цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, түүний төлөвлөлт, зохион байгуулалтын явцад туршлага, сургамж, үр дүнг тооцож ажиллана.

2.11.Цагдаагийн байгууллагын дотоод хяналт-аюулгүй байдлын нэгж ажиллагааны өмнөх сургалтын явцад цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн байдалд цагдаагийн багийн захирагчтай хамтран хяналт тавьж, зөрчил гаргасан алба хаагчийг зохих журмын дагуу хариуцлага тооцох ажлыг хариуцан ажиллана.

2.12.Энэ журмын 2.4-т заасан захирагч нь ажиллагааны үеийн сургаж бэлтгэх төлөвлөлт, зохион байгуулалт, цагдаагийн алба хаагч, багийн үүрэг гүйцэтгэлт,

ажиллагааны цагийн байдлын талаар 24 цаг тутам, шаардлагатай үед тухай бүр цагдаагийн төв байгууллагад мэдээлнэ.

### **Гурав.Ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг шалгаж үнэлэх, сонгох**

3.1.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хамрагдсан цагдаагийн алба хаагч нэг бүрийн мэдлэг, үүрэг гүйцэтгэх чадвар, цагдаагийн багийн жигдрэлтийг энэ журмын 2.3-т заасны дагуу шалгаж үнэлнэ.

3.2.Энэ журмын 2.6-д заасан цагдаагийн алба хаагчаас НҮБ-аас гаргасан үйл ажиллагааны “Ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие даасан алба хаагчийг үнэлэх журам (Assessment For Mission Service of Individual Police Officers)”-ын дагуу шалгаж үнэлэх ажлыг зохион байгуулна.

3.3.Ажиллагаанд сонгох ажиллагаа нь дараах хэлбэртэй байна:

- 3.3.1.бие даасан цагдаагийн алба хаагчийн;
- 3.3.2.цагдаагийн тусгай мэргэшсэн баг;
- 3.3.3.цагдаагийн баг.

3.4.Ажиллагааны албан тушаалын ангилал, цагдаагийн цолны зэрэглэл, гүйцэтгэх үүргийн онцлогийг харгалзан дараах албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг хамруулна:

3.4.1.энэ журмын 3.3.1-д заасан “бие даасан цагдаагийн алба хаагч”-НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааны цагдаагийн албанд бие даан цагдаагийн алба хаагч (зөвлөх)-аар томилогдон үүрэг гүйцэтгэх цагдаагийн офицер, ахлагчийг;

3.4.2.энэ журмын 3.3.2-т заасан “цагдаагийн тусгай мэргэшсэн баг”-НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааны цагдаагийн албанд тусгай мэргэжил, мэргэшлийн дагуу багаар ажиллахаар томилогдон үүрэг гүйцэтгэх цагдаагийн офицер, ахлагчийг;

3.4.3.энэ журмын 3.3.3-т заасан “цагдаагийн баг”-НҮБ-аас тогтоосон зохих бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон бүх төрлийн зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдаж, тавигдсан үүргийг биелүүлэх чадавх бүхий энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон нэгжийг.

3.5.Энэ журмын 3.3.1-д заасан цагдаагийн алба хаагчид дараах шаардлага тавигдана:

3.5.1.ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтэй, өөрийн сайн дураар зөвшөөрсөн байх;

3.5.2.цагдаагийн албанд 3-аас дээш жил ажилласан;  
Тайлбар: Цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан хугацааг оруулж тооцохгүй.

3.5.3.Олон улсын хэлний мэдлэгийн унших, бичих, сонсох, ярих чадвар нь анхан дунд буюу B1 түвшинээс дээш (Европын улсуудын гадаад хэлний чадварыг тодорхойлох шалгуур CEFR олон улсын стандарт);

3.5.4.механик хурдны хайрцагтай автомашин жолоодох чадвартай, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх хүчинтэй байх;

3.5.5.буудлага үйлдэх, галт зэвсэгтэй харьцах чадвартай, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;

3.5.6.компьютерын албан хэрэглээний программ ашиглах чадвартай;

3.5.7.НҮБ-аас гаргасан журамд заасан 55 нас хүрээгүй, эрүүл мэндийн шаардлага хангасан;

Тайлбар: НҮБ-ын цагдаагийн албаны сонгон шалгаруулалтад орох өдөр 55 нас хүрээгүй байхыг ойлгоно.

3.5.8.гадаад паспортын хүчинтэй хугацаа дуусаагүй байх;

3.5.9.сонгон шалгаруулалтад оролцох үедээ гэмт хэрэгт холбогдон шалгагдаагүй байх.

3.6.Энэ журмын 3.3.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цагдаагийн алба хаагч 3.5-д заасан шаардлагыг хангасан байхаас гадна НҮБ-ын цагдаагийн албанаас зарласан тусгай мэдлэг, мэргэшил, мэргэжлийн ур чадварын шаардлагыг хангасан байна.

3.7.Энэ журмын 3.3.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох алба хаагчид дараах шаардлага тавигдана:

3.7.1.цагдаа, цэргийн сургуулийн анхан шатны бэлтгэл, сургалтад хамрагдсан байх;

3.7.2.цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцтой холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актыг судалсан байх;

3.7.3.бие бялдрын ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

3.7.4.ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлтэй, өөрийн сайн дураар зөвшөөрсөн байх;

3.7.5.цагдаа, цэргийн албаны зохих шатны мэдлэгтэй, мэргэжлийн болон багаар ажиллах ур чадвартай байх;

3.7.6.Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1-д заасан алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх;

3.7.7.хамт олны дунд нэр хүндтэй, зан харьцаа, ёс суртахууны хувьд төлөвшсөн, гэмт хэрэг, сахилгын зөрчил гаргаагүй байх;

Тайлбар: Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дууссан байх.

3.7.8.тухайн жилд алба хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингээр 70-аас дээш үнэлэгдсэн байх;

3.7.9.сонгон шалгаруулах Ажлын хэсгээс заасан эмнэлгийн байгууллагын үзлэгээр орж, биеийн эрүүл мэндээр тэнцсэн байх;

3.7.10.механик хурдны хайрцагтай автомашин жолоодох чадвартай, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх энэ шалгалт зохион байгуулагдахаас 2 жилийн өмнө олгогдсон байх;

3.7.11.буудлага үйлдэх, галт зэвсэгтэй харьцах чадвартай, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.

3.8.Энэ журмын 3.3.2, 3.3.3-т заасан цагдаагийн багт удирдах болон зарим алба хаагчид дараах тусгай шаардлага тавигдана:

3.8.1.цагдаагийн багийн захирагч, захирагчийн орлогч үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч нь 10-аас дээш жил цагдаагийн албанд ажилласан, үүнээс удирдах албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан, цагдаагийн хошуучаас дээш цолтой, англи хэлний анхан дунд (B1) шатны мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.2.ажиллагааны, холбогч, жижүүрийн офицероор үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч нь 6-аас дээш жил цагдаагийн албанд ажилласан, цагдаагийн ахмадаас дээш цолтой, англи хэлний анхан дунд (B1) шатны мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.3.ар тал, хангалтын алба хаагчаар үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч нь 6-аас дээш жил цагдаагийн албанд ажилласан, тухайн ажиллагаанд тавигдах хэлний анхан дунд (B1) шатны мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.4.эмчээр үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч нь, тухайн ажиллагаанд тавигдах хэлний ахисан анхан (A2) шатны мэдлэгтэй, эрүүл мэндийн эмчлэх эрхийн гэрчилгээтэй, шийдвэр гаргах чадвартай байх.

3.9.Ажиллагаанд оролцох цагдаагийн багийн гүйцэтгэх үүргийн онцлогийг харгалзан цагдаагийн алба хаагч, багт тавигдах нэмэлт шаардлагыг цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр тогтоож болно.

3.10.Цагдаагийн алба хаагчаас дараах хэлбэр, төрлөөр шалгалт авна:

- 3.10.1.биеийн тамирын бэлтгэл;
- 3.10.2.Олон улсын хэлний бэлтгэл;
- 3.10.3.замын хөдөлгөөний дүрэм, жолоодлогын дадлага;
- 3.10.4.мэргэжлийн ур чадвар;
- 3.10.5.хууль, эрх зүйн бэлтгэл;
- 3.10.6.галт зэвсэг ашиглах, эзэмших бэлтгэл;
- 3.10.7.сэтгэл зүйн сорил.

3.11.Энэ журмын 3.10.1, 3.10.4, 3.10.5, 3.10.6-д заасан шалгалтыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын дагуу зохион байгуулна.

3.12.Энэ журмын 3.10.2-т заасан шалгалтыг НҮБ-аас гаргасан үйл ажиллагааны “Цагдаагийн багийн үүрэг гүйцэтгэх чадавхыг үнэлэх журам (Assessment of Operational Capability of Formed Police Units For Service in United Nations Peacekeeping operations and Special Political Missions)”-ын дагуу зохион байгуулна.

3.13.Энэ журмын 3.10.3-т заасан шалгалтыг механик хурдны хайрцагтай автомашин (4x4)-ыг жолоодох ур чадварыг автодром дээр, замын хөдөлгөөнд оролцуулж зохион байгуулна.

3.14.Энэ журмын 3.10.7-д заасан шалгалтыг цагдаагийн төв байгууллагаас томилогдсон сэтгэл зүйчдийн баг мэргэжлийн түвшний арга, аргачлалын тусламжтайгаар алба хаагч, ажилтны бие хүний онцлог, сэтгэл зүй, сэтгэл санааны байдал, харилцаа, хандлага, төлөвшил, сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, оюун ухааны хөгжлийн зарим онцлогийг судлах, хэмжих, тодорхойлох аргаар зохион байгуулна.

3.15.Энэ журмын 3.3.1, 3.3.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цагдаагийн алба хаагчаас НҮБ-аас гаргасан үйл ажиллагааны “Ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие даасан алба хаагчийг үнэлэх журам (Assessment For Mission Service of Individual Police Officers)”-ын дагуу зохион байгуулна.

3.16.Алба хаагч нь ажиллагаанд оролцох хүсэлтээ анги, байгууллагын даргад бичгээр гаргана.

3.17.Энэ журмын 2.3-т заасан нэгжид дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.17.1.тухайн оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор анги, байгууллага нь жилийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөлттэй уялдуулан ажиллагаанд үүрэг гүйцэтгэх боломжтой бүрэлдэхүүний мэдээллийн жагсаалтыг;

3.17.2.тухайн жилд ажиллагаанд оролцуулах бүрэлдэхүүний тоог 15 хүртэлх хувийн нөөцийн бүрэлдэхүүнтэй байхаар ажиллагаа тус бүрээр тогтоож, төлөвлөгөө, графикийг;

3.17.3.анги, байгууллага нь энэ журмын 3.3.3-т заасан багт оролцох хүсэлт гаргасан алба хаагчаас энэ журмын 3.12-т заасан шалгалтыг авч тэнцсэн алба хаагчдын хүсэлт, ажлын үзүүлэлт, эрүүл мэнд, сахилга хариуцлагын байдлыг даргын зөвлөлийн хурлаар хүн нэг бүрээр хэлэлцэн шийдвэр, холбогдох материалыг.

3.18.Ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагч нь дараах материалыг бүрдүүлнэ:

3.18.1.сайн дурын үндсэн дээр ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлт бүхий гараар бичсэн өргөдөл;

3.18.2.ажил байдлын тодорхойлолт;

3.18.3.байгууллагын даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл;

3.18.4.офицер, ахлагчийн үнэмлэхийн хуулбар;

3.18.5.сүүлийн 3 сард авхуулсан 4х6 см-ийн хэмжээтэй цээж зураг  
3 хувь;

3.18.6.гадаад паспортын хуулбар (хүчинтэй хугацаа 3-аас дээш  
жил);

3.18.7.жолоодох эрхийн үнэмлэхийн хуулбар.

3.19.Энэ журмын 3.3.3-т заасан багт орох алба хаагч нь гүйцэтгэх албан тушаалын үүргийн онцлогоос шалтгаалан жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн дамжаа төгссөн сертификатын хуулбарыг нэмэлтээр бүрдүүлнэ.

3.20.Энэ журамд заасан цагдаагийн алба хаагч, багийг сонгох ажиллагааг цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон комисс зохион байгуулна.

3.21.Энэ журмын 3.3-т заасан сонгох ажиллагаанд орох алба хаагчийн биеийн эрүүл мэндийн байдлыг Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын хавсралтаар

баталсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-д заасны дагуу комиссоос заасан эмнэлгийн байгууллагын үзлэгээр орж, эмнэлгийн комисс тодорхойлж, дүгнэлт гаргана.

3.22.Энэ журмын 2.3-т заасан нэгж нь энэ журмын 3.3.3-т заасан сонгох ажиллагааг цагдаагийн байгууллагын веб сайт /<https://www.police.gov.mn/>-аар нээлттэй зарлана.

3.23.Цэрэг, цагдаагийн зохих шатны сургууль, дамжаа төгссөн, шинэ албан тушаалд томилогдсоноос хойш 24 сараас доошгүй хугацаагаар алба хаасан офицер, ахлагч ажиллагаанд оролцох хүсэлт гаргаж болно.

3.24.Цагдаагийн алба хаагч өмнө нь 6 сарын хугацаагаар үүрэг гүйцэтгэсэн бол 12 сарын дараа, 12 сарын хугацаагаар үүрэг гүйцэтгэсэн бол 24 сарын дараа дахин ажиллагаанд оролцох хүсэлт гаргаж болно.

3.25.Дараах алба хаагчийн хүсэлтийг хүлээн авахгүй:

3.25.1.баримт бичиг дутуу бүрдүүлсэн;

3.25.2.эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаагүй;

3.25.3.гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд холбогдож эрх бүхий байгууллагад шалгагдаж байгаа;

3.25.4.энэ журмын 3.24-т заасан хугацааг баримтлаагүй бол;

3.25.5.Дотоод хэргийн их сургууль болон бусад их, дээд сургууль, коллежийн өдрийн ангийн сургалт, дамжаанд сурч байгаа;

3.25.6.Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй.

3.26.Сонгох ажиллагаатай холбоотой аливаа маргаантай асуудлыг комисс тухай бүр хянан шийдвэрлэнэ. Комиссын шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл цагдаагийн төв байгууллагын даргад гомдол гаргаж болно.

3.27.Ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, шалгаж үнэлэх, сонгох ажлын үр дүн болон цагдаагийн багийн удирдлага, багийг томилуулах асуудлыг энэ журмын 2.3-т заасан нэгж, хүний нөөцийн нэгжтэй хамтран цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, цагдаагийн алба хаагч, багийг ажиллагааны газар орон руу илгээхээс 7 хоногийн өмнө саналаа хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Дөрөв.Ажиллагааны үеийн удирдлага, зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх**

4.1.НҮБ-ын дүрмийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр НҮБ-ын эсхүл бүс нутгийн холбогдох олон улсын байгууллагын явуулж байгаа олон үндэстний ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг дараах байдлаар удирдлага, зохион байгуулалтаар хангана:

4.1.1.Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн - Төрийн захиргааны нэгдсэн удирдлагыг;

4.1.2.Цагдаагийн төв байгууллагын дарга ажиллагаанд оролцож буй Монгол Улсын цагдаагийн алба хаагч, багийн – Захиргааны дэмжлэг үзүүлэх болон мэргэжлийн удирдлагыг;

4.1.3.НҮБ, Олон Улсын байгууллагаас томилсон бүрэн эрхт Тусгай төлөөлөгч, Цагдаагийн комиссар - Ажиллагааны (тактикийн) удирдлагыг;

4.1.4.Ажиллагааны нэгжийн дарга - Цагдаагийн алба хаагч, багийн захиргааны удирдлагыг;

4.2.Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь цагдаагийн төв байгууллагын энэ журмын 3.27-д заасан санал болгосноор ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагч, цагдаагийн багийг томилно.

4.3.Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн нэгж нь алба хаагчийн үүрэг гүйцэтгэсэн талаарх цагдаагийн багийн захирагчийн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн тухайн алба хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэл хийнэ.

4.4.Цагдаагийн төв байгууллага нь ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн урьд эрхэлж байсан албан тушаалыг хэвээр хадгалж, цалин хөлсийг бүрэн олгоно. Албан тушаалын цалин хөлсийг түүнтэй байгуулсан гэрээг үндэслэн итгэмжлэгдсэн этгээдэд олгож болно.

4.5.Ажиллагаанд цагдаагийн багт үүрэг гүйцэтгэх алба хаагчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгалд хамруулна. Даатгалд хамруулахтай холбогдон гарах зардлыг Цагдаагийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд жил бүр тусгана.

4.6.Цагдаагийн алба хаагч, багийг Монгол Улсаас ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр ниссэн өдрөөс үүрэг гүйцэтгэж эхэлсэнд тооцно.

4.7.Алба хаагч, цагдаагийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүн нь ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үедээ Монгол Улсын цагдаагийн албаны нэр хүндийг өндөрт өргөж, Монгол Улсын хууль тогтоомж, цагдаагийн албанд мөрдөгдөж буй дүрмүүд, эрх зүйн хэм хэмжээ, НҮБ-ын дүрэм, олон улсын гэрээ, тухайн ажиллагааны удирдлагаас тогтоосон дүрэм, журмыг чанд сахиж, ажиллагаа явагдаж байгаа улсын хууль тогтоомж, ёс заншлыг хүндэтгэнэ.

4.8.Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн алба хаагч, багийн үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны цагийн байдлын талаар хагас жил тутам, шаардлагатай үед тухай бүр хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдээлнэ.

4.9.Ажиллагааны талаарх зөвшөөрөгдсөн мэдээллийг олон нийтэд хүргэх, алба хаагчийг ар гэртэйгээ холбогдох нөхцөлийг бүрдүүлэх, хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газраар уламжлан Нотариатын тухай хуульд заасан үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, цагдаагийн алба хаагч, багийг мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангах үүргийг цагдаагийн төв байгууллага хариуцна.

4.10.Ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө ажиллагааны газар орноос эгүүлэн татна:

4.10.1.Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, цагдаагийн албанд мөрдөгдөж буй дүрэм, журмууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын гэрээгээр тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн;

4.10.2.Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн нэгжтэй байгуулсан гэрээний үүргийг зөрчсөн;

4.10.3.эрүүл мэндийн шалтгаанаар үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй тухай холбогдох байгууллага, албан тушаалтны дүгнэлт гарсан;

4.10.4.цолны журам, албан тушаалын захирах, захирагдах ёс, сахилга, ёс зүйг зөрчсөн.

4.11.Энэ журмын 4.10.1, 4.10.2, 4.10.4-т заасан шалтгаанаар хугацаанаас нь өмнө ажиллагааны газар орноос эгүүлэн татахтай холбогдон гарах зардлыг тухайн алба хаагч хариуцна.

4.12.Ажиллагаанаас эгүүлэн татсан алба хаагчийн оронд үүрэг гүйцэтгэх цагдаагийн байгууллагын алба хаагчийг дараах хугацааг харгалзан цагдаагийн төв байгууллагын даргын санал болгосноор хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, ажиллагааны газар орон руу илгээхтэй холбогдон гарах зардлыг “Цагдаагийн хөгжлийн сан”-гаас санхүүжүүлнэ.

4.12.1.зургаан сарын хугацаатай ажиллагаанд дөрвөн сар үүрэг гүйцэтгэхээр бол;

4.12.2.арван хоёр сарын хугацаатай ажиллагаанд зургаан сар үүрэг гүйцэтгэхээр бол.

4.13.Ажиллагаанд цагдаагийн багийн удирдлага, алба хаагчаар үүрэг гүйцэтгэж буй алба хаагч ээлжийн амралт, чөлөөгөөр явах хугацаандаа зорчих хөдөлгөөн, аяллын мэдээллийн талаар цагдаагийн төв байгууллагын энэ журмын 2.3-т заасан нэгжид мэдэгдэнэ.

4.14.Цагдаагийн багийн үүрэг гүйцэтгэлттэй холбоотой баримт бичгийг цагдаагийн багийн удирдлага хариуцан архивлаж, дараагийн цагдаагийн багт цахимаар, цагдаагийн төв байгууллагад хэвлэмэл байдлаар хүлээлгэн өгнө.

4.15.Цагдаагийн багийн ээлж хүлээлцэх, эгүүлэн татах ажиллагааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар томилогдсон комисс зохион байгуулах бөгөөд комисс тайлангаа ажиллагаа дууссанаас хойш 7 хоногийн дотор, шаардлагатай үед тухай бүр танилцуулна.

4.16.Цагдаагийн алба хаагч, багийн үүрэг гүйцэтгэх хугацааг Монгол Улсын хилээр нэвтрэн орж ирсэн өдрөөр дуусгавар болсонд тооцно.

4.17.Цагдаагийн алба хаагч, багийн захирагч үүрэг гүйцэтгэсэн тухай тайланг эх орондоо ирснээс хойш 7 хоногийн дотор цагдаагийн төв байгууллагын даргад, 14 хоногийн дотор хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

4.18.Үүрэг гүйцэтгэх хугацаанд онцгой амжилт гаргаж, гавьяа байгуулсан алба хаагчийг цагдаагийн багийн захирагчийн тодорхойлолтыг үндэслэн шагнаж урамшуулж болно.

4.19.Ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагч, багийн тайланг цагдаагийн төв байгууллагын энэ журмын 2.3-т заасан нэгж нэгтгэн боловсруулж, туршлага, сургамж, үр дүнг тооцсон баримт бичгийн эмхэтгэл гарган ажиллана

4.20.Цагдаагийн алба хаагч ажиллагааны өмнөх сургалт болон ажиллагаанд үүрэг гүйцэтгэхдээ дараах байдлаар цагдаагийн цолыг түр хэрэглэнэ:

4.20.1.салааны эргүүл, харуул, хамгаалалтын цагдаагийн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн дэд ахлагч;

4.20.2.ар тал, хангалт, засвар, үйлчилгээ хариуцсан албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн ахлагч;

4.20.3.ар тал, хангалт хариуцсан мэргэжилтэн (нярав), сувилагч албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн ахлах ахлагч;

4.20.4.салааны тасгийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэн, хүний их эмч албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн дэслэгч;

4.20.5.салаан дарга, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн ахлах дэслэгч;

4.20.6.жижүүрийн офицер, холбогч офицер, ар тал хангалтын офицeroop үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн ахмад;

4.20.7.ажиллагааны офицер албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн хошууч;

4.20.8.захирагчийн орлогч албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн дэд хурандаа;

4.20.9.захирагчийн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагч цагдаагийн хурандаа.

4.21.Энэ журмын 4.20-д заасан цол нь зөвхөн ажиллагааны өмнөх сургалт болон ажиллагааны үед үүрэг гүйцэтгэх хугацаанд хэрэглэх бөгөөд үүрэг гүйцэтгэж дууссаны дараа өмнөх цолыг үргэлжлүүлэн хэрэглэнэ.

4.22.Алба хаагч эрхэлж байгаа албан тушаал, олгосон цолноос үл харгалзан ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэл болон ажиллагаанд үүрэг гүйцэтгэхдээ энэ журамд заасан цагдаагийн цолыг хэрэглэх үүрэгтэй бөгөөд цолны дарааллаар захирах, захирагдах ёсыг баримтална.

4.23.Ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэл болон ажиллагаанд алба хаагч үүрэг гүйцэтгэхдээ цагдаагийн байгууллагын “Дүрэмт болон ажлын хувцас хэрэглэх журам”-ын дагуу хувцсыг өмсөж хэрэглэнэ.

4.24.Ажиллагааны үед хэрэглэгдэх зэвсэг, техник, материал хэрэгсэл, өмч хөрөнгийг НҮБ-тай байгуулсан гэрээ, санамж бичигт зааснаар шийдвэрлэх бөгөөд цагдаагийн багийн захирагч, удирдлага нь тухайн өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

4.25.Ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчийн үүрэг гүйцэтгэсэн хоногийн тооцоог энэ журмын 2.3-т заасан нэгж энэ журмын 4.6, 4.16-д заасныг баримтлан хүн нэг бүрээр тооцож, ажлын 5 хоногт багтаан цагдаагийн төв байгууллагын санхүү, ар талын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

4.26.Ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн багийн бие бүрэлдэхүүний томилолтын зардлыг Засгийн газраас тогтоосон хэмжээ, энэ журмын 4.25-д тооцсон

хугацааг үндэслэж олгох бөгөөд гадаад валютын ханшийг цагдаагийн багийн сүүлчийн ээлж эх орондоо ирсэн өдрийн Монгол банкны ханшаар тооцно.

4.27.Энэ журмын 4.10.1-4.10.4-т заасан шалтгаанаар үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө ажиллагааны газар орноос ирсэн алба хаагчид үүрэг гүйцэтгэсэн хугацааны томилолтын зардлыг энэ журмын 4.25-д заасныг баримтлан олгоно.

4.28.Ажиллагаанд цагдаагийн багийн бие бүрэлдэхүүн, зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, эд хөрөнгийг оролцуулсны нөхөн төлбөрийн орлогыг бүрэн бүрдүүлэхтэй холбогдсон арга хэмжээг ажиллагааны газар орон дээр цагдаагийн багийн захирагч хариуцна.

4.29.Энэ журмын 4.15-д заасан комиссын томилолт, визний хураамж, тээврийн зардлыг “Цагдаагийн хөгжлийн сан”-аас санхүүжүүлнэ.

4.30.Цагдаагийн багийн бүрэлдэхүүнд нэгдсэн хангалтаар ажиллагааны газар оронд тохирох 2 ээлжийн дүрэмт хувцас, хэрэглэлээр хангана.

4.31.Энэ журмын 4.30-д заасан хувцас, хэрэглэлийн хангалтыг цагдаагийн байгууллагын санхүү, ар тал хариуцсан нэгж зохион байгуулж, санхүүжилтийг зохих хууль, журмын дагуу Сангаас шийдвэрлүүлнэ.

### **Тав.Бусад зүйл**

5.1.Шаардлагатай тохиолдолд алба хаагчийн үүрэг гүйцэтгэлт, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, эд хөрөнгийн ашиглалт, чанар байдалд хяналт хийх, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, шалган туслах зорилгоор цагдаагийн байгууллагын Ажлын хэсгийг ажиллагааны газар оронд болон бие бүрэлдэхүүний байгаа газарт томилон ажиллуулж болно.

5.2.Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--оОо--

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны  
11 дугаар сарын 21-ны өдрийн 1120  
тушаалын хоёрдугаар хавсралт

## **ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН АЛБА ХААГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙ, БИЕ БЯЛДРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ, СУВИЛАХ ЖУРАМ**

1. Энэ журмын зорилт нь Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2. Журам болон Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг баримтлана.

3. Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг Цагдаагийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.

4. Цагдаагийн төв байгууллага энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулна.

5. Үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулна.

6. Алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээлт, сувиллын аль төрөлд хамруулах, түүний амрах хугацаа, сувилах үйлчилгээний хэмжээг эмчийн дүгнэлтээр тогтооно.

7. Цагдаагийн төв байгууллага алба хаагчийг нөхөн сэргээх, сувилуулах зорилгоор "Сүүж-Уул" сэргээн засах амралт, сувилалд хөнгөлөлттэй үнээр, эсхүл төлбөргүйгээр сувилуулж, амраана.

8. Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүйг сэргээх чиглэлээр цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчдийн баг гаргаж, дор дурдсан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- а) цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүйн байдлыг судлан оношлох;
- б) сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх;
- в) сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;
- г) сэтгэл зүйн ярилцлага хийх;
- д) сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх шаардлагатай гэж үзвэл харьяалах эрүүл мэндийн байгууллагад холбон зуучлах.

9. Алба хаагчийг сувилах, эрүүл мэнд, сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, болзошгүй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн төв байгууллагаас хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлнэ.

--oOo--